



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.4.15 № 02/109-ГАГ2013/02


Гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж  
ажиллах тухай

Монгол Улсын Ерөнхий Аудиторт ҮАГ-аас 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн “Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн”-гийн аудитаар тус газраас 2012 онд улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгах явцад Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн оффисын барилгын ажил хугацаандаа хийгдээгүй зөрчил илэрлээ.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна. Үүнд:

Тус газрын харьяа Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн оффисын барилгын ажлын гүйцэтгэгч “Батцагаан Өргөө” ХХК нь тайлант онд гэрээгээр гүйцэтгэх ажлаа хийж дуусаагүй, гүйцэтгэлээ гаргаж өгөөгүйгээс 403.0 сая төгрөгийн эрх үүсээгүй байна. Ийм учраас хөрөнгийн эх үүсвэрийг 2013 оны төсвийн тодотголд суулган тухайн барилгын ажлыг дуусгаж 2013 оны 12 дугаар сарын 05-ны дотор Үндэсний аудитын газарт хариу ирүүлэхийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Ц.Пүрэвдорж, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Б.Өэлүн-Үжин нарт даалгав.

АХЛАХ АУДИТОР



С.СЭРЧХОРОЛ